

Ганбаатарын Галдан^{1,✉}, Накамүра Дайсүкэ²

¹Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр
²Сайтама Их сургууль, Либерал Урлагийн факультет,
Япон улс, Сайтама хот, 338-8570, Шимо-Окубо 255, Сакүра-кү,

**Археологийн дурсгалын нэрийн гажуудал:
Дорнод Монголын хүрэл ба түрүү төмрийн үеийн археологийн
дурсгалын жишээн дээр**

Товчлол. Манай орны археологийн дурсгалуудын нэрс зарим талаараа учир дутагдалтай байгаа талаар өмнө нь судлаачид чамгүй олон удаа хөндөн өөрсдийн саналаа дэвшүүлж байсан ч дийлэнх нь нэг талын өнцгөөс өнгөц харж байсан. Энэ нь дурсгалын нэрийг солих, өөрчлөх тал дээр анхаарч байсан бол энэ удаад бид аливаа дурсгалын нэрийг өөрчлөх тухай биш арай өөр өнцгийн гажуудлын талаар өгүүлэх болно. Тодруулбал, хөрш зэргэлдээ, бүс нутгийн хийгээд бүүр цаашлаад дэлхийн археологийн дурсгалд ховорхон тохиолддог гажуудал манай орны ялангуяа дорнод Монголын хүрэл ба түрүү төмрийн үеийн чулуун байгууламжит бүх археологийн дурсгалын нэрсэнд тохиолдоод байна. Хөрш зэргэлдээ болон бүс нутгийн хэмжээнд бүртгэгдээд байгаа түүхийн олон үеийн дурсгалын нэрс анх өгөгдсөн магадгүй сүүлд шинэчлэгдсэн нэрс ямар нэгэн өөр гадаадын түүх бичлэгт үндсэн дуудлагаараа галиглагдан ашиглагддаг бол манай орны зарим дурсгалын нэр гадаад оронд орчуулагдан ашиглагдсаар байна. Нэг төрлийн дурсгал өөрийн гадаад хэлбэрийн онцлогоороо орон орны түүх бичлэгт тогтсон орчуулгаар хэвшсэн бол өөр нэг дурсгал 3-4 өөр орчуулгаар манай орны төдийгүй бусад гадаад орны түүх бичлэгт бичигдсээр байна. Үүнийг бид гажуудал хэмээн харж байгаа ба маш энгийнээр энэхүү асуудлаас гарах боломж байгааг ажиглан өөрийн саналаа дэвшүүлээ. Мөн цаашид археологийн шинээр илэрсэн дурсгалд нэр өгөх анхан шатны онол, загварын саналыг тусгалаа. Үүнд, Монгол орны нутгаас илрээд буй археологийн дурсгалын нэрийг нэгдүгээрт, гадаад хэлэнд орчуулахгүй байх, хоёрдугаарт, орон нутгийн судлаачид маань оноосон нэрийн дүрмийг баримтлах, цаашдаа шинээр илрүүлсэн дурсгал эсвэл шинэ соёлд тухайн дурсгалын гадаад хэлбэр онцлогт тохирсон нэр бус харин дурсгалыг анх илрүүлсэн малтсан газрын орны нэрийг өгөх тэр дундаа уламжлалт орон нутгийн нэрийг ашиглах нь оновчтой болов уу гэсэн энгийн боловч археологийн шинжлэх ухаан төдийгүй бусад нийгэм, байгалийн шинжлэх ухааны онолын түвшинд хэлэлцүүлдэг сэдвийг хөндсөн болно.

Түлхүүр үг: Хүрэл ба түрүү төмрийн үе, дорнод Монгол, Дөрвөлжин булш, Шоргоолжин булш, Улаан зуух хэлбэрийн дурсгал, Тэвшийн соёл, хөрвүүлэг

Galdan Ganbaatar^{1,✉}, Nakamura Daisuke²

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia
²Faculty of Liberal Arts, Saitama University,
338-8570, Shimo-okubo 255, Sakura-ku, Saitama, Japan

Issue of anomalous names of Archaeological Sites: On example of Archaeological Sites of the Bronze and Early Iron Age in Eastern Mongolia

Summary. In the past, researchers has raise their opinions on the fact that the names of archaeological sites in our country are somewhat inadequate, but most of them looked at it superficially from one sided point of view. While it focused more on renaming and changing the name of the archaeological sites, in this time it is not about changing the name of any monument, but it will talk about a slightly different angle of distortion. Specifically, we talked about the distortions that rarely occur in neighboring, regional and even global archaeological monuments, especially in the names of all archaeological sites of the Bronze Age and Early Iron Age in Eastern Mongolia. The names of cultures and monuments recorded in the neighborhood and region are used as transliterations in the historical records of other countries, while the names of some monuments in our country are still translated and used in foreign archaeological records. One type of site has been used in the country due to its external features, while another monument is still recorded in the annals of our country as well as other foreign countries in 3-4 different translations. I see this as a deviation, and I put forward my proposal after observing that there is a possibility to get out of this problem very simply.

Key words: *Bronze Age and Early Iron Age, Eastern Mongolia, Dörvöljin Grave, Shorgooljin Grave, Ulaan zuukh type, Tevsh culture, convert*

Удиртгал

Дэлхийн археологийн шинжлэх ухааны хөгжлийн түүхэнд дурсгалд нэр оноох асуудал хэд хэдэн арга замаар явж иржээ. Үндсэндээ өвөг түүхийн дурсгалд нэр өгөх болон бичгийн сурвалжтай буюу түүхэн үеийн дурсгалд нэр өгөх гэж ангилаад өвөг түүхийн дурсгалд нэр өгөхдөө олдсон, судлагдсан газрын орон нутгийн нэр дээр нэмж дурсгалын төрлийг бичнэ [Renfrew and Bahn 1991: 63] гэжээ. Мөн газар усны уламжлалт эртний нэрийг ашиглах нь чухал хэмээн цохон тэмдэглэсэн байна [Renfrew and Bahn 1991: 63]. Энэхүү онолоос үзэхэд дурсгалд нэр өгөхөд орон нутгийн нэр чухал бөгөөд энгийн боловч дахин давхцахгүй давуу талтай болох нь тодорхой. Мөн археологийн дурсгалд нэр өгөхөд анхдагчийн зарчим баримтлах нь зүй [Төрбат 2014: 17] хэмээн үзэх тохиолдол байдаг. Хэдий анхдагчийн зарчим чухал ч мөн зарим талаараа өрөөсгөл болохыг хойно дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Монгол оронд археологийн судалгаа эхэлсэн анхны жилүүдээс дурсгалыг нэрлэх тал дээр онолын төвшинд гажуудаж эхэлсэн ч бид үүнийг төдий л анзааралгүй өнөөг хүрсэн билээ. Мөн анзаараагүйн дээр дахин энэ алдааг давтах аюултай байгаа учир заавал залруулах шаардлагатай болоод байна. Тус онолын гажуудал нь бусад орны археологийн судалгаанд төдий л тохиолдохгүй байгаа ч манай орны археологийн судалгаанд сүүлийн жилүүдэд илүүтэйгээр элбэг тохиолдож байгааг [Ц.Төрбат 2014] судлаачдын онолын түвшний мэдлэг тааруу байгаатай холбосон.

Энэхүү өгүүлэлд маш тодорхой хэдэн гажуудлын талаар өгүүлэх ба түүнийг залруулах ямар боломж байгааг мөн хөндлөө.

Гажуудлын эхлэл

1925 онд Зөвлөлтийн археологич Г.И.Боровка өөрийн “Ар Монгол” [1927] зохиолдоо Туул голын савд тохиолдсон нийт чулуун байгууламжит дурсгалыг ялгах үүднээс хавтгай хавтан чулуу ашигласан чулуун дараастай дурсгалыг “плиточная могила” гэсэн нэрээр тухайн дурсгалыг нэрлэжээ [Боровка 1927: 54-55]. Үүнээс харахад нэг зууны өмнө судлаач маань орон нутгийн уламжлалт нэр байтугай ажиллаж буй орны эх хэлнээс өөр гадаад нэр өгсөн том алдаа гаргасан байна. Утгачлан монгол хэлэнд орчуулбал “Хавтант булш” бөгөөд 1950-иад оноос манай орны судлаачид нутагтаа бие даан судалгаа хийж эхлэхдээ “Плиточная могила” дурсгалыг өөрсдийн хэл орчуулан “Хавтгай чулуут булш” [Пэрлээ 1957: 42] хэмээн нэрлэснээс хойш уг булшны ерөнхий хэлбэр төрх, байгуулж босгосон бүтэц зэргийг үндэслэн “Дөрвөлжин булш” гэх оноосон нэр өгч, Монголын археологийн түүх бичлэгт өргөн хэрэглэгдсээр өнөөг хүржээ [Наваан 1975; Сэр-Оджав 1965; Эрдэнэбаатар 2002; Батсайхан 2002; Төрбат нар 2003; Амартүвшин, Жаргалан 2010; Амартүвшин 2016; Төрбат, Эрдэнэболд 2020].

Гажуудлын даамжрал

Нэгдүгээр асуудал. Энд нэгэн эргэлзээтэй зүйл ажиглагдаж байна. Энэ нь оноосон нэрийн дүрмийн асуудал юм. Оноосон нэрийг дэлгэрэнгүй товч ямраар ч бичсэн том үсгээр эхэлж бичнэ, оноосон нэрийн төгсгөлийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэхгүй, гадаад хэлэнд орчуулдаггүй гэх олон шинжийг агуулдаг [Өнөрбаяр 2004]. Энэ дүрмийн үндсэн шинж дэлхийн улс орны бичгийн дүрэмд бүгд ижил байдаг. Харин 1927 онд

Зөвлөлтийн судлаач маань энэ дурсгалыг өөрийн бүтээлдээ “плиточная могила” гэж жижиг үсгээр бичсэнээс үзвэл тэрээр магадгүй тус дурсгалд оноосон нэр өгөөгүй байсан бололтой юм. Гэтэл манай орны археологийн түүх бичлэгт ч мөн адил “дөрвөлжин булш”, “дөрвөлжин булшны соёл” гэх оноосон нэр маань өгүүлбэрийн эхэнд л биш бол жижиг үсгээр бичигддэг дүрмийн алдааг тоочин бичвэл тоймгүй билээ.

Энд “яагаад” гэсэн асуулт яахын аргагүй урган гарна. Мөн манай Монголын судлаачдын гардаг энэ түгээмэл алдаатай асуудал сүүлийн жилүүдэд анхаарлыг маань ихээр татах болсон бөгөөд гайхшируулах өөр нэгэн асуудалтай дахин “яагаад” гэдэг асуулттай тулна. Энэ нь хөрш зэргэлдээ орны нутгаас анхлан илрээд тухайн орныхоо оноосон нэр авсан дурсгалуудыг Монголын археологийн түүх бичлэгт оноосон нэрийн дүрмийг ягштал баримталдаг асуудал юм. Бид гэхдээ энд тэр бүрийг тоочин бичиж нуршилгүйгээр тун ойлгомжтой ганц жишээ авахад, НТӨ I мянганы эхний хагаст хамаарах Алтай нурууны бүсэд тархсан чулуун дарааст булшийг XIX зуунд анх “Пазырык” хэмээх газарт малтан Евроазийн археологийн түүх бичлэгт “Пазырыкийн соёлын булш” хэмээн нэрийдсээр өнөөг хүржээ [Батсүх 2016]. Энэ дурсгал манай орны баруун бүс Алтайн нурууны салбар уулсад цөөнгүй бүртгэгдэн нэлээд олныг малтан судалсан [Батсүх 2014]. Энэ төрлийн дурсгалын талаар манай орны судлаачид аливаа ном бүтээлд бичихдээ өгүүлбэрийн хаана ч орсон “Пазырык булш”, “Пазырыкийн булш”, “Пазырыкийн соёлын булш” гэх зэргээр бичдэг [Төрбат 2020] хэрнээ “дөрвөлжин булш”, “дөрвөлжин булшны соёл” [Төрбат, Эрдэнэболд 2020] хэмээн жижиг үсгээр бичих нь хачирхалтай. Үүнээс гадна нэг зуун жилийн өмнө гарсан дээрх гажуудал даамжирсаар XX зууны сүүлийн хагаст ирэхэд дорнод Монголын нутгаас нэгэн өвөрмөц хэлбэртэй дурсгал илэрч судалгааны бүтээлд тэмдэглэгдэх болсон нь “шоргоолжин булш” юм [Наваан 1984; Эрдэнэбаатар, Ковалев 2008]. Энэхүү дурсгалын оноосон нэрээр 2000-аад оны эхэн үеэс нэлээд их оролдсон [Очир 2015] ч эцсийн дүндээ “Шоргоолжин булш” гэх нэрэн дээрээ тогтож [Амартүвшин 2020] байх шиг байна. Энэ удаад бид дахин нэрийг өөрчлөх талаар гаргасан олон санал загварын талаар энд тоочин нуршихыг хүссэнгүй. Харин нэрийн хэрэглээ болон өөр бусад асуудлын талаар өгүүлье. Өмнөх “Дөрвөлжин булш” оноосон нэрийн асуудал, өгүүлбэрийн дунд мөн л жижиг үсгээр бичих тохиолдол тун түгээмэл байна [Наваан 1975; Батсайхан 2002; Эрдэнэбаатар 2002; Төрбат нар 2003; Төрбат, Эрдэнэболд 2020].

Хоёрдугаар асуудал. Мөн л оноосон нэрийн дүрмийг зөрчинө. Дээр дурдсан оноосон нэрийг

гадаад хэл рүү оруулдаггүй гэх дүрмийг манай орны төв, өмнөд болон дорнод бүс нутгаар тархсан “Дөрвөлжин булш”-ийг Оросын судлаачид. “плиточная могила” [Боровка 1927; Цыбыктаров 1998], англи хэлэнд “Slab grave/burial” [Honeychurch et al 2004; Jargalan 2017; Taylor et al 2019] хятад хэлэнд “石板墓 /shíbǎn mù/ гэх мэтээр улс болгон өөрийн хэл рүү шууд орчуулан хэрэглэдэг. Гэхдээ бүгд оноосон нэрийн том үсгээр бичдэг дүрмийг ягштал баримтлах аж. Гэтэл дээр авсан жишээг дахин авахад аль ч орны хэлэнд “Пазырык” гэх үндсэн нэр алдагдахгүй “Pazyryk tomb” англиар, япон хэлэнд “パジリクの墓/Pajiriku no haka”, хятад хэлэнд 巴泽雷克文化 /bā zé léikè wénhuà/ гэж ашиглагдана.

Мөн “Дөрвөлжин булш”-тай ижил гадаад хэл рүү орчуулагддаг. Орос хэлэнд “фигурная могила” [Гришин 1980] хэмээн мөн л харагдах байдал, ерөнхий хэлбэрийн онцлогт тохирсон нэршил өгсөн. Мэдээж “фигурный могила”-г англи хэлт судлаачид маань утгачлан орчуулан хэрэглэсэн. Орчуулан хэрэглэхдээ өнөө хэр хэвшин тогтоогүй байна [Амартүвшин 2016; Miyamoto 2018; Taylor et al 2019; Wright 2021]. Тодруулбал, “Shaped burial/grave, Figured grave, Hourglass shaped burial” гэх мэт хэд хэдэн янзаар орчуулан хэрэглэж байна. Энэ мэт Хятад, Солонгос, Японы судлаачид өөрсдийн хэл дээр утгачилан орчуулан хэрэглэж байгаа нь тодорхой. Гуравдугаар асуудал. 2004 онд Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань хар ууланд малтсан дугуй хэлбэрийн манаас чулуутай дөрвөлжин давхар хашлагатай булш [Амартүвшин нар 2007],

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Улаан зуухад малтсан тэгш өнцөгт хэлбэрийн хашлагатай, дугуй манаас чулуутай булш [Наваан нар 2008] археологийн түүх бичлэгт өвөрмөц оршуулгын зан үйлээрээ өмнө тэмдэглэгдсэн дурсгалаас ялгаран тэмдэглэгдэж эхэлсэн. Тухайн 2 дурсгалт газар ажилласан судлаачид тус дурсгалыг эхэн үедээ Дөрвөлжин булштай төстэй хэв шинжтэй ч оршуулгын зан үйлийг онцгойлон, утга санааг тайлбарлах оролдлогыг хийсэн [Амартүвшин нар 2007; Түмэн нар 2010]. Үүнээс хойш энэ төрлийн дурсгалын судалгаа эрчимжин Монгол орны өмнөд бүс, дорнод Монголын нутгаас нэлээд олон газраас шинээр бүртгэн тэмдэглэж малтан судалсаар байна [Амартүвшин нар 2019; Хатанбаатар 2019]. Энэ удаад тэр бүрийг тоочих шаардлагагүй бөгөөд гол асуудал руугаа орьё. Эхэн үедээ дээрх 2 дурсгалт газар анх малтлага судалгаа хийсэн судлаачид анхны малтлагын үр дүн хэвлүүлэхдээ 2 талд Дөрвөлжин булшны хэв шинжтэйг цохсон байгаа [Амартүвшин нар 2007, Түмэн нар 2010] нь тохиолдлын хэрэг биш бөгөөд энэ төрлийн дурсгал нь анх магадгүй Дөрвөлжин

Монгол нэр	Орос орчуулга	Англи орчуулга
Шоргоолжин булш (Наваан 1984; Эрдэнэбаатар, Ковалев 2008; Очир 2015; Хатанбаатар. 2019; Амартүвшин 2021)	Фигурная могила (Цыбиктаров 1998)	Hourglass shaped grave (Амартүвшин. 2016) Figured grave (Mi- yamoto 2018) Shape burial (Tay- lor et al 2019)
Хэлбэрт булш (Амартүвшин, Жаргалан 2010)		
Дамар хэлбэрийн булш (Батсүх нар, 2022)		

Хүснэгт 1. Шоргоолжин булшны Орос, Англи орчуулга

булшны 4 ангиллын нэг нь байсныг үгүйсгэхгүйг энд тэмдэглэх нь зүйтэй. Харин сүүлийн үеийн судалгаагаар энэхүү дурсгал маань Дөрвөлжин булшнаас он цагийн хувьд харьцангуй эрт, оршуулга болон чулуун байгууламжийн бүтцийн хувьд эрс өөр, илүүтэйгээр Шоргоолжин булштай төстэй [Амартүвшин нар 2015; Хатанбаатар 2019] хэмээгээд энэ төрлийн оршуулгын зан үйлтэй дурсгалуудыг дотор нь ангилах оролдлого хийж эхэлсэн [Хатанбаатар 2019; Амартүвшин 2020]. Ингэхдээ судлаач Д.Хатанбаатар (2019), тус 2 газрын дурсгалыг хоорондоо ялгаагүй нэг төрлийн дурсгал хэмээн үзэн Улаан зуух хэлбэрийн булш [Хатанбаатар 2019], судлаач Ж.Уирайт (2021) мөн нэг төрлийн хүрээнд багтаан Улаан зуух хэлбэрийн дурсгал [Wright 2021] хамааруулсан бол судлаач Ч.Амартүвшин (2020; 2021) дээрх 2 дурсгалт газарт малтсан дурсгалыг 2 тусдаа төрөлд хуваасан [Амартүвшин 2020; Амартүвшин 2021]. Дөрөвдүгээр асуудал. Энэхүү дурсгалаар дагнан судалгаа явуулж буй судлаачид ийм оршуулгын өвөрмөц зан үйлтэй дурсгалыг Алтай нуруунаас дорнод Монгол, Галбын говиос Өвөр Байгал хүртэл байна хэмээгээд гадаад байгууламжийн олон төрөл байгааг онцлоод “Түрүүлгэ харуулсан оршуулгат булш” хэмээн нэрлээд англи хэлээр “Prone burial” [Амартүвшин 2016; Хатанбаатар 2019; Амартүвшин 2021], орос хэлээр “Захоронение ничком” хэмээн хэвшүүлэх санал дэвшүүлсэн [Амартүвшин 2021]. Шинэ тутам эрчимтэй судлагдаж байгаа дурсгалд нэр өгөх чухал хэдий ч бид мөн л 100 жилийн тэртээ гаргасан алдаагаа дахин давтахад ойрхон байна.

“Түрүүлгэ харуулсан оршуулгат булш” нэрэнд ямар алдаа байна вэ?

Нэгдүгээрт: Археологийн дурсгалд оноосон нэр өгөх гэх үндсэн шалгуурт нийцэхгүй байна.

Хоёрдугаарт: Мөн л орчуулаад эхэлсэн;

Гуравдугаарт: Оршуулга байхгүй ч гадаад хэлбэрийн хувьд дээрх дурсгалын дийлэнхтэй хэлбэрийн хувьд ижил дурсгалыг “булш” гэсэн нэрийн доор оруулж байгаа нь;

Дөрөвдүгээрт: Хөрш зэргэлдээ, бүс нутгийн хийгээд дэлхий нийтийн археологийн дурсгалд болон соёлын нэрийг үйлдэл заасан үйл үгтэй өгүүлбэрээр нэрлэсэн байгаа эсэхийг судлаачид маань нягталсан болов уу гэх мэт анхаарууштай хэд хэдэн асуудал байна.

Санал 1

Түрүүлгэ нь харуулсан оршуулгат дурсгал (Prone burial) нэрийн хувьд археологийн дурсгалд цаашлаад археологийн соёлыг нэгтгэсэн нэр байхад хэтэрхий өрөөсгөл мэт санагдана. Учир нь хамгийн ойрын жишээ Чандмань хар уул, Улаан зуухд болон Дэлгэрхаан ууланд малтсан энэ төрлийн дурсгалын оршуулгын давтамж бага 2013, 2015-2019 онуудад хийгдсэн хайгуулаар нийт 800 гаруй бүртгэгдсэн байгаагийн 50 хувьд оршуулга илрэхгүй байх магадлал өндөр. Иймд энэхүү нэрийг эргэн харах үнэхээр нэгтгэн нэрлэх шаардлагатай бол оноосон нэр өгөх саналтай байна. Гэхдээ энэ удаагийн нэгтгэн нэрлэх оролдлого анхны биш, өмнө нь судлаачид нэгтсэн соёлд хамааруулах санал гаргаж байсан билээ [Эрдэнэбаатар, Ковалев 2008; Honeychurch 2016]. Бидний хувьд соёл болон хэв шинжийн нэрээр анхдагчийн зарчмыг баримтлан “Тэвшийн соёл”, “Тэвшийн хэв шинжийн дурсгал” [Эрдэнэбаатар, Ковалев 2008] хэмээх нэрийг дэмжих саналтай байгаагаас гадна “Улаан зуух”, “Чандмань хар уул” хэлбэрийг нэгтгэн “Улаан зуух хэлбэрийн дурсгал” хэмээн нэрлэх саналыг дэвшүүлж байна. Учир нь тухайн дурсгалт газруудад малтсан дурсгал хэв шинжийн хувьд хоорондоо ижил, тухайн газрын материалын (чулууны) онцлогоосоо хамаараад үл ялиг өөр мэт харагдах хэдий ч анх байгуулсан зарчим, эдийн соёлын адилсал, он цагийн давхцал зэрэгт үндэслэн нэг төрлийндурсгал болгох нь цаашид судлах судлаачдын толгойг эргүүлэхгүй байх давуу талтай. Хэрэв өөр гэж үзэх шаардлага гарвал Дэлгэрхаан ууланд бүртгэгдсэн энэ төрлийн дурсгалын цогцолборт багтах дугуй том цагариг байгууламж [Амартүвшин нар 2017], эсвэл эргэн тойронд нь зарим тохиолдолд байх тэгш өнцөгт хэлбэртэй урд талдаа үүд бүхий дагуул байгууламжаар [Амартүвшин нар 2016; 2017] нь “DKU type” болгох боломжтой. Гэхдээ шаардлагатай бол гэсэн маань заавал хооронд нь ялгаж тус тусад нь нэрлэх шаардлагагүй гэсэн

<i>Чандмань хар уулын хэлбэр (CKU type)</i>	<i>Улаан зуухын хэлбэр (DKU type)</i>
<i>Уртаргын дагуу цувраа байрлалтай бүлэг</i>	<i>Уртаргын дагуу цувраа байрлалтай бүлэг</i>
<i>Урд болон хойд талдаа жижиг дагуултай</i>	<i>Урд болон хойд талдаа жижиг дагуултай</i>
<i>Дугуй манаас чулуутай</i>	<i>Дугуйвтар, дугуй манаас чулуутай</i>
<i>Давхар хашлага</i>	<i>Давхар хашлага</i>
<i>Өргөргийн дагуу булшны нүх</i>	<i>Өргөргийн дагуу булшны нүх</i>
<i>(Хэрвээ оршуулгатай байвал)</i>	<i>(Хэрвээ оршуулгатай байвал)</i>
<i>Түүрүүлэг харуулсан оршуулгатай</i>	<i>Түүрүүлэг харуулсан оршуулгатай</i>
<i>Улаан чулуун (цөөн) болон цагаан жижиг (олон) зүүлт гардаг</i>	<i>Улаан чулуун (цөөн) болон цагаан жижиг (олон) зүүлт гардаг</i>
<i>Шавар савны хагархай</i>	<i>Шавар савны хагархай</i>
<i>Чулуун эдлэл</i>	<i>Чулуун эдлэл</i>
<i>НТӨ XV-XII зуунд хамаарна</i>	<i>НТӨ XV-XII зуунд хамаарна</i>

Хүснэгт 2. Чандмань хар уул, Улаан зуухд малтсан булшны харьцуулалт

санааг илэрхийлж, үндсэн тэгш өнцөгт хэлбэрийн давхар хашлагатай чулуун байгууламжит дурсгалыг цаашид малтан судлах, хайгуулаар бүртгэх ном бүтээл бичих шаардлагатай болсон тохиолдолд “Улаан зуух хэлбэрийн дурсгал” хэмээвэл зүгээр болов уу хэмээн үзэж байна.

Санал 2.

Дээр өгүүлсэн бүх дурсгалын нэрийг гадаад хэл рүү орчуулахгүй зөвхөн хөрвүүлэн хэрэглүүлж хэвшүүлэх санал дэвшүүлж байна. Энэ нь магадгүй болон янзын орчуулгаасбусад орны судлаачдын толгойг эргүүлэхгүй байх давуу талтайгаас гадна маш энгийн ойлгомжтой болох билээ. Цаашид энэ мэтчилэн шинээр илэрсэн дурсгал орчуулгын хэрэг байхгүйгээр зөвхөн орон орны хэлэнд нь хөрвүүлээд хэрэглэдэг зарчмыг баримтлаад хэвшвэл нэн амар санагдах юм.

Төгсгөл

Өнгөрсөн зууны эхээс манай оронд явагдаж байгаа археологийн судалгаагаар олон зуун шинэ нээлт ололт амжилт дүүрэн байсан ч түүнийгээ дагаад чамгүй их алдаа эндэгдэл байсан нь тодорхой. Гэхдээ алдаа эндэгдэл бол аль ч орны шинжлэх ухаанд байдаг зүйл бөгөөд түүнийг залруулан улам төгөлдөржүүлэх нь судалгаа шинжилгээний ажлын гол зарчим юм. Энэхүү өгүүлэлд өөрийн хувьд алдаатай, гажуудал буюу оновчтой бус гэсэн сэдвийн хүрээнд үндэслэл, санал, гаргалгаа

дэвшүүлээ. Магадгүй өөр судлаачдын хувьд эсрэгээрээ байхыг үгүйсгэхгүй. Ийн археологийн дурсгал, соёлын нэрийн асуудал цаашид ямар зарчмыг баримталбал илүү ойлгомжтой, хялбар, хэвшүүлбэл зохилтой вэ гэсэн өөрийн загварыг дор товчвол, Шинээр илрүүлсэн, өмнө тэмдэглэгдэж байгаагүй бүтэц зохион байгуулалттай дурсгалыг нэрлэхдээ тухайн орон нутгийн уламжлалт нэрийг ашиглах;

-Монгол хэлний оноосон нэрийн дүрмийг баримтлах;

-Гадаад хэл рүү орчуулахгүй байх (дурсгалыг нэрлэх оноосон нэр);

-Дурсгалын гадаад хэлбэр болон дотоод зохион байгуулалтын онцлогт шинжээр дурсгалд нэр оноохгүй байх гэсэн энгийн ойлгомжтой цөөн зүйлс дээр анхаарвал, цаашдаа гарах эндүүрэл, алдаанаас зайлсхийх боломжтой мэт санагдана.

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 01 сарын 31

Өгүүлэл засварласан: 2023 оны 03 сарын 31

Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 6 сарын 30

Ном зүй

Амартүвшин нар 2007 – Амартүвшин Ч., Ерөөл-Эрдэнэ Ч., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б. Эртний нүүдэлчдийн оршуулгын зан үйлийн өвөрмөц нэгэн хэлбэр. – *Studia Archaeologica*. Tom (IV) XXIV. fasc 11. - Улаанбаатар. тал 126-141.

Амартүвшин, Жаргалан 2010 – Амартүвшин Ч., Жаргалан Б. Хүрэл зэвсгийн үеийн булшны судалгаа. - Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага газрын чулуу”. – *Studia Archaeologica*. Tom (VII) XXVII. - Улаанбаатар. тал - 78.

Амартүвшин нар 2015 – Амартүвшин Ч., Батболд Н., Эрэгзэн Г., Батдалай Б. Чандмань Хар уулын археологийн дурсгал I. - Улаанбаатар. тал - 21, 23, 65-68.

<i>Тэвишийн соёл</i>		
<i>Улаан зуухын төрөл</i>	<i>Шоргоолжин булш</i>	<i>Бусад</i>
<i>(Дагуул нэмэлт байгууламжийн хамт)</i>		<i>(Дөрөө, Дамар)</i>

Хүснэгт 3. Санал нэг: Дурсгалыг болон соёлын нэршил

д/д	Дурсгалын нэрс	Орос хөрвүүлэг. Рус	Англи хөрвүүлэг. eng
1	Тэвшийн соёл	Культура Тэвиш	Tevsh Culture
2	Шоргоолжин булш	Шоргоолжин могила	Shorgooljin Grave
3	Улаан зуухын төрөл	Улан зуухынскии тып	Ulaanzuukh Type
4	Дөрвөлжин булш	Дурвүлдэжин могила	Dörvöljin Grave

Хүснэгт 4. Санал хоёр: Дурсгалуудын нэрийн хөрвүүлэг

Амартүвшин 2016 – Амартүвшин Ч. Дөрвөлжин булшны соёл. – Монголын археологийн өв II. – Эртний Монголчуудын булш оршуулгын дурсгал. – Улаанбаатар.

Амартүвшин нар 2019 – Амартүвшин Ч. Батзориг О. Батдалай Б. Ханбогдын археологийн дурсгал. – Улаанбаатар.

Амартүвшин 2020 – Амартүвшин Ч. Түрүүлгэ харуулсан оршуулгат булш. – Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил. – Улаанбаатар. тал – 22-50.

Амартүвшин 2021a – Амартүвшин Ч. Чандмань хар уулын булш. – Монголын археологийн нэвтэрхий толь. – Улаанбаатар. тал - 351

Амартүвшин 2021b – Амартүвшин Ч. Улаан зуухын булш. – Монголын археологийн нэвтэрхий толь. – Улаанбаатар. тал - 260

Батсайхан 2002 – Батсайхан З. Хүннү. – Улаанбаатар.

Батсүх 2014 – Батсүх Д. Монгол дахь Пазырыкийн үеийн булшны судалгаа. – Хүрэл, түрүү төмрийн үе ба Хүннүгийн өмнөх соёлын судалгааны асуудал. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. – Улаанбаатар. тал - 49-63

Батсүх 2016 – Батсүх Д. Пазырыкийн соёлын булш. – Монголын археологийн өв II. – Эртний Монголчуудын булш оршуулгын дурсгал. – Улаанбаатар.

Батсүх нар, 2022 – Батсүх Д., Цэлхагарав Ц., Броседдер., Гантулга Ж. Монгол-Германы хамтарсан “Баркор” төслийн 2022 оны судалгааны ажлын товч үр дүн. – Монголын Археологи-2022. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. – Улаанбаатар. тал - 66

Боровка 1927 – Боровка Г.И. Археологическое обследование среднего течения р.Толы. – Северная Монголия II. Предварительные отчеты лингвистической и археологической экспедиций о работах, произведенных в 1925 году. – Ленинград. стр 54-55.

Гантулга 2014 – Гантулга Ж. Хүрэл, түрүү төмрийн үеийн оршуулгын дурсгалын нэр томъёоны асуудалд. – Хүрэл, түрүү төмрийн үе ба Хүннүгийн өмнөх соёлын судалгааны асуудал. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн

эмхэтгэл. – Улаанбаатар. тал – 20-49

Гришин 1980 – Гришин Ю.С. О “фигурных” плиточных могилах Забайкалья и Монголии. - КСИА. Вып 162. Изд., Наука. Москва. стр -12-15.

Наваан 1975 – Наваан Д. Дорнод Монголын хүрлийн үе. – Улаанбаатар.

Наваан 1984 – Наваан Д. Монгол-Зөвлөлтийн археологичдын хамтын ажиллагаа. - Улаанбаатар. тал - 35-36.

Наваан нар 2008 – Наваан Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д., Түмэн Д. Дорнод Монгол төслийн хүрээнд 2008 онд хийж гүйцэтгэсэн археологийн хээрийн судалгаа. – Mongolian Journal of Archaeology, Anthropology and Ethnology. Vol 4. №1 (312). -Улаанбаатар. тал 3-36.

Очир 2015 – Очир Б. Шоргоолжин булш. – Studia Historica. Tom XLIII. fasc. 2. Улаанбаатар. тал- 306-311.

Пэрлээ 1957 – Пэрлээ Х. Монгол орны археологийн шинжилгээний товч тойм. – Улаанбаатар.

Төрбат нар 2003 – Төрбат Ц., Эрдэнэбат У., Амартүвшин Ч. Эгийн голын сав нутаг дахь археологийн судалгаа. – Улаанбаатар. тал – 33-35

Төрбат 2014 – Төрбат Ц. Монгол Алтайн хүрлийн үеийн судалгааны тулгамдсан асуудлууд. – Хүрэл, түрүү төмрийн үе ба Хүннүгийн өмнөх соёлын судалгааны асуудал. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. – Улаанбаатар.

Төрбат, Эрдэнэболд 2020 – Төрбат Ц., Эрдэнэболд Л. Дөрвөлжин булшны тархац, түүний эздийн оршуулгын ёс, онцлог. – Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил. – Улаанбаатар. тал – 87-116.

Төрбат 2021 – Төрбат Ц. Пазырыкийн соёлын оршуулгын ёс. – Монголын археологийн нэвтэрхий толь. – Улаанбаатар. тал – 207-209

Хатанбаатар 2019 – Хатанбаатар Д. Монголын хүрлийн үеийн түрүүлгэ харуулсан оршуулгат булшны судалгаа. – Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. – Улаанбаатар. тал – 3-272.

Цыбыктаров 1998 – Цыбыктаров А.Д. Культура плиточных могил Монголии и Забайкалья. – Улан-Удэ. стр - 126-128, 168, 283.

Сэр-Оджав 1965 – Сэр-Оджав Н. Монголын төв, умард хэсгийг археологийн талаар судлан шинжилсэн нь. – Монголын хүрлийн үе. Улаанбаатар.

Түмэн нар 2010 – Түмэн Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д., Анхсанаа Г., Ванчигдаш Ч. Дорнод Монгол төслийн хүрээнд гүйцэтгэсэн археологийн хээрийн судалгаа. - *Mongolian Journal of Archaeology, Anthropology and Ethnology*. Vol 6. №1 (365). УБ. тал - 3-56.

Эрдэнэбаатар 2002 – Эрдэнэбаатар Д. Монгол нутаг дахь дөрвөлжин булш, хиргисүүрийн соёл. – Улаанбаатар. тал 62-66

Эрдэнэбаатар, Ковалев 2008 – Эрдэнэбаатар Д., Ковалев А.А. Тэвшийн соёл. – Улаанбаатар Их Сургууль. НУФ. – Нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний бичиг. 4(3). Улаанбаатар. тал – 5.

Honeychurch et al 2004 – Honeychurch, W., Wright, J., Amartuvshin, C. The Egiin Gol Survey: A “stepped” approach to spatial data. - 69th Meetings of the Society for American Archaeology, Montreal.

Jargalan 2017 – Jargalan B. Pastoralists, Communities, and Monumentality during the Mongolian Bronze Age. - Ph.D. dissertation, Department of Anthropology, Yale, New Haven, CT.

Miyamoto 2018 – Miyamoto, K. (ed.). Excavations at Emeelt tolgoi Site: The Third Report on Joint Mongolian-Japanese Excavations in Outer Mongolia, Department of Archaeology, Kyushu University, Fukuoka.

Renfrew and Bahn 1991 – Renfrew C., Bahn P. *Archaeology: Theories, Methods and Practice*. – New York. pp-63.

Taylor et al 2019 – Taylor W., Wilkin S., Wright J., Dee M., Erdene M., Clark J., Tuvshinjargal T., Baryarsaikhan J., Fitzhugh W., Boivin N. Radiocarbon dating and cultural dynamics across Mongolia’s early pastoral transition. – *Plos one* 14 (11). Research article.

Wright 2021 – Wright J. Prehistoric Mongolian Archaeology in the Early 21st. Century: Developments in the Steppe and Beyond. - *Journal of Archaeological Research* 29. pp-431–479



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.